

Шведийн Вант Улсын Боловсролын удирдах газрын харьяа Стокгольм дүүргийн хэлний товийн монгол хэлний багш нараас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "ЭХ ХЭЛ-АМЖИЛТЫН ТҮЛХҮҮР" одорлог 4 дэх жилдээ 2018 оны 4 дүгээр сарын 21-ний одор амжилттай зохион байгуулагдав.

Уг одорлогийн зорилго нь эх хэлээ хойч үедээ овлүүлэх, Швед улсад сурч, амьдарч буй залууст тус улсын боловсролын системийн талаарх шинэ мэдээ мэдээллийг огох, Швед улсын ахлах болон их дээд сургуульд элсэн орох талаар зовлогоо огоход чиглэдэг.

Энэхүү арга хэмжээний үеэр "Хос жигүүр" тов, Стокгольм дүүргийн дунд сургуульд суралцаж буй бага ангийн сурагчдын цагаан толгойн "Эрдмийн баяр" болсоноос гадна хос хэлээрх "Манжин" жүжигчилсэн тоглолт үзэгчдийн сонирхолыг ихэд татлаа. Мон оюутан Т.Чинзориг, А.Анар, Б.Урандол нар их дээд сургууль, гимназид хэрхэн элсэн орох талаарх илтгэлийг тавьж, багш нарын зүгээс боловсролын системийн тогтолцоонд анхаарах асуудлаар иргэдэд мэдээлэл, зовлогоо огов.

